

Stage 1 – Ground skimming (yellow)

Ground skimming is gliding near the ground over smooth terrain, below a few meters (not higher than you would care to fall).

Instructional and safety recommendations**Objective**

This stage introduces the student to paragliding and enables him to discover the first feelings of flying within safe limits. This stage is probably the most important in the whole progression, since here is founded the basis for good (or bad) decisions and habits. The student shall, in safe proximity to the ground, fly easy equipment in easy environment and conditions, to gain confidence in flying, the equipment, and himself. Here he practices and learns the basic skills.

Methods

Teaching has been traditionally on training slopes. However, flying close to the ground asks for a precise control with little time to react and makes paragliding one of the most demanding air sports. To start with the easiest practice (controlling a straight flying line before teaching to take off and land), alternate methods are available now, like winch towing with low tensions close to the ground, or tandem first flights as an introduction. Only a couple of minutes of in-flight control, or even just displaying a film from an on-board camera can dramatically ease the student's first steps.

Proper environment

It is smooth terrain, preferably snow, sand, grass or gravel, with a profile that allows for ground skimming with the paraglider used. The take-off and landing areas and the space between should be free of obstacles and other hazards with a good margin to any side. It should be possible to do the whole flight close to a straight line.

Warning

It is warned against attempts to take off and fly in unstable conditions, cross, down, strong or gusty wind. The student shall not practice stalls (except for the landings) or more than gentle turns with only small diversions from the flight path. Trying to work any type of lift can be especially dangerous. The reason is the closeness to ground gives little time or altitude for corrections. The student shall also avoid flying alone. When all rating requirements have been met... The student shall, when flying without direct supervision of the instructor, only fly in beginner environment in stable conditions with light and smooth headwinds.

Before progressing to the next stage

It is of vital importance that the student knows the basic theory and master all skills, since weaknesses here may lead to the most serious consequences when he gets higher and flies in more difficult conditions. It is especially important that he demonstrates correct procedures, routines and checks in his preparation before flight, to ensure nothing is forgotten, overseen,

1-р шат – Газарт ойр нислэг (шар)

Газарт ойр нислэг гэдэг нь зөөлөн, жигд гадаргуутай орчинд, газраас дээш хэдхэн метрийн (унахад аюулгүй) өндөрт гулсах нислэгийг хэлнэ.

Сургалтын болон аюулгүй ажиллагааны зөвлөмжүүд**Зорилго**

Энэ шатанд суралцагч параглайдингийн спортод хөл тавьж, аюулгүй хязгаарын дотор нисэх анхны мэдрэмжээ авна. Сайн (эсвэл муу) шийдвэр, зуршлуудын суурь тавигдах учраас магадгүй хамгийн чухал шат байх. Суралцагч аюулгүй өндөрт буюу газарт ойр, тааламжтай орчин нөхцөлд, удирдахад хялбар далавч хэрэгслээр нисэхдээ нислэг, далавч хэрэгсэлдээ болон өөртөө итгэх итгэл олж авна. Ингэхдээ үндсэн чадваруудад суралцаж, дадлага хийнэ.

Заах арга барил

Сургалтыг налуу энгэр, хяр газар явуулна. Гэхдээ газарт ойрхон нислэг үйлдэнэ гэдэг нь хариу үйлдэл хийх цаг бараг байхгүй учраас маш нарийн удирдлага шаардана гэсэн үг. Хамгийн энгийн дадлагаас (гараа хийх, газардахыг заахаас өмнө шулуун нислэгийн шугамаа хянах) эхлэхдээ өнөө үед янз бүрийн арга хэрэглэж болно. Жишээ нь, газарт ойр, бага хүчээр татлагатай гараа хийх, эсвэл эхний нислэгийг тандем маягаар хийх. Хоёрхон минутын нислэгийн үеийн удирдлага хийлгэх, эсвэл нислэгийн үеэр хийсэн бичлэг үзүүлсэн ч суралцагчийн эхний алхмыг асар их хөнгөвчилж өгнө.

Тохиромжтой орчин

Зөөлөн газар буюу цас, элс, өвс, нарийн хайргатай бол газарт ойр гулсах нислэг үйлдэхэд тохиромжтой. Гарааны болон газардах талбай, тэдгээрийн хоорондох орон зай ямар ч саадгүй, аюул эрсдэл учруулах зүйлгүй, аль аль тал руугаа уужим тавиу байх ёстой. Нислэг бүхэлдээ шулуун шугамын дагуу явагдах боломжтой байх ёстой.

Анхаарах зүйл

Тогтворгүй нөхцөлд, хажуугийн, арын, хүчтэй болон шилжлэг салхитай нөхцөлд гараа хийхийг хориглоно. Суралцагч (газардахаас бусад тохиолдолд) далавч хаах дадлага хийхгүй. Мөн нислэгийн шугамаас маш бага хазайх зөөлөн эргэлт л хийж болно. Ямар нэгэн өргөлтөнд орох оролдлого хийх нь тун аюултай. Учир нь газарт дэндүү ойрхон байх үед засах цаг ч, хангалттай өндөр ч байхгүй. Суралцагч бие даан, ганцаараа нисэхгүй. Энэ шатны бүх шаардлагыг хангасан цагтаа суралцагч сургагч багшийн шууд удирдлагагүй нисэж болох ч зөвхөн тогтвортой нөхцөлд, өөдөөс үлээх бага зэргийн, зөөлөн салхитай үед л ниснэ.

Дараагийн шатанд дэвшихээс өмнө

Суралцагч үндсэн онолоо мэдэж, бүх чадваруудаа гартаа оруулах нь амин чухал. Учир нь дараагийн шатанд илүү өндөрт, илүү хүнд нөхцөлд нисэх учраас энд сул талууд байх юм бол ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй. Нислэгийн өмнөх бэлтгэлийг хийхдээ зөв дэс дарааллаар далавч хэрэгсэлдээ тогтмол үзлэг хийж, ямар нэгэн зүйл мартсан, орхисон, буруу угсарсан, тохируулсан эсэхээ шалгана. Бүр

wrongly assembled or adjusted. Equipment failures, malfunctions or omission errors are best avoided by developing proper habits from the very beginning. He should begin to understand the judgement required to choose safe flying conditions for his skills level.

SKILL REQUIREMENTS

- Transport, care: Of paraglider and equipment
- Equipment routines: Assembly, unfolding sail on ground, moving it when needed, daily check, adjustment, disassembly
- Preflight check: Connections, conditions, visualizing run or flight, clear area
- Raising sail and control (including aborting take-off): On flat ground and on slope
- Take-off: Sight forward, acceleration and trajectory control, gradual loading of glider
- Flight control: Correct airspeed and directional control, smooth corrections
- Landing: Directly into wind, sight forward, ready to run, using glider as a brake
- Proper PLF emergency landing

KNOWLEDGE REQUIREMENTS

Aircraft

- Terminology: Material and parts
- Safety equipment: Helmet, quality sunglasses, boots, gloves, clothing, harness

Aerodynamics

- Nature of flying: Dependent on continuous forward airspeed
- Airspeed, groundspeed: Why take off and land into the wind
- Control inputs: Brakes/weight shift, banking, turning, airspeed control

Meteorology

- Wind: Wind meters, natural indicators and signs
 - Velocity: m/s, km/h, knots or mph
 - Direction: Compass and quadrants (head or up, tail or down, crosswinds)
 - Force: Increases with the square of the wind velocity, effects, dangers
- Conditions: Recognition of safe and dangerous conditions

Safety

- Preparation: Standard routines and checks, double-check of critical factors (consider paraglider + harness as a complete aircraft)
- Exercises: Description, intention, procedures, execution, errors and dangers

EXPERIENCE REQUIREMENTS

- At least 2 practice days

эхнээсээ зөв зуршлыг өөртөө суулгаснаар далавч хэрэгсэл доголдох, буруу ажиллах, алдаа гарахаас сэргийлнэ. Өөрийнхөө үр чадварын түвшинд тохирохуйц аюулгүй нислэгийн нөхцлийг сонгох, үнэлэх чадвартай байх ёстойг суралцагч ойлгож эхэлнэ.

ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ УР ЧАДВАР

- Далавч хэрэгслээ зөв тээвэрлэх, арчлах
- Далавч, суудал, бусад хэрэгслээ холбох, салгах, газарт дэлгэх, хэрэгтэй үед өөр газарт шилжүүлэх, өдөр тутмын үзлэг хийх, тохируулга хийх, салгах
- Нислэгийн өмнөх үзлэг: холболтууд, орчин нөхцөл, гүйлт ба нислэгээ төсөөлөн харах, орчин саадгүй эсэхийг шалгах
- Далавчаа босгох, ханалтандаа байлгах (гарааг цуцлах): тэгш газар болон хяр дээр
- Гараа: Урагш чиглэлтэй, гүйхдээ хурд авах болон хөдөлгөөний чиглэлээ хянах, далавчаа аажмаар асаах
- Нислэгийн хяналт: агаар дахь хурд болон чиглэлийг хянах, бага зэргийн засвар хийх
- Газардах: салхины эсрэг, хараа эгц урагш, гүйх бэлтгэлтэй, далавчаа хаах
- Шүхрээр ослын буулт зөв хийх техник

ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ МЭДЛЭГ

Нисэх төхөөрөмж (параглайдер)

- Нэр томъёо: материал болон бүрэлдэхүүн хэсгүүд
- Хамгаалалтын хэрэгслүүд: дуулга, сайн чанарын нарны шил, гутал, бээлий, өмсгөл, суудал

Аэродинамик

- Нислэгийн мөн чанар: агаар дахь үргэлжилсэн давших хурдаас хамааралтай
- Агаар дахь болон газрын хурд: яагаад салхины эсрэг гараа хийх, газардах ёстой вэ?
- Далавчаа хянах үйлдлүүд: Тоормос/биеийн шилжилт, хазайлт, эргэлт, агаар дахь хурдыг хянах

Цаг уур

- Салхи: салхи хэмжигч төхөөрөмж, байгалийн шинж тэмдэг, үзүүлэлтүүд
 - Хурд: м/с, км/цаг, knot=1.852 км/ц, миль/цаг
 - Чиглэл: компас, квадрант (өөдөөс, хойноос, хөндлөн салхи)
 - Хүч: Салхины хурд, нөлөөлөл, аюул зэргээс хамааран өсөх
- Нөхцөл: Аюултай ба аюулгүй нөхцлийг таних чадвар

Аюулгүй ажиллагаа

- Бэлтгэл: Стандартын дагуу байнга хийгдэх үзлэг, чухал хүчин зүйлсийг дахин давтан шалгах (далавч+суудал бол бүрэн хэмжээний нисэх төхөөрөмж)
- Дасгал: Тодорхойлолт, зорилго, дүрэм журам, гүйцэтгэл, алдаа ба аюул осол

ДАДЛАГА

- Дор хаяж 2 бүтэн өдөр дадлага хийх

<p>ATTITUDE REQUIREMENTS</p> <ul style="list-style-type: none"> The instructor shall be convinced that the student can take care of his own and others' safety while ground skimming, within the instructional and safety recommendations given. 	<p>ХАНДЛАГА</p> <ul style="list-style-type: none"> Газарт ойр гулсах нислэг хийхдээ суралцагч өгөгдсөн зааварчилга, аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хүрээнд өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж чадна гэсэн итгэл үнэмшил сургагч багшид төрсөн байх ёстой.
<p style="text-align: center;">Stage 2 – Altitude gliding (orange)</p>	<p style="text-align: center;">2-р шат – Өндөрт гулсах нислэг (улбар шар)</p>
<p>Altitude gliding is gliding with enough height and distance from the terrain to be able to maneuver relatively freely.</p> <p>Instructional and safety recommendations</p> <p>Objective</p> <p>This stage introduces the student to gliding with height and distance to the terrain, enables him to enjoy flying within safe limits. At this stage, the student gradually becomes accustomed to flying well clear of the ground, and should begin to lose height anxiety. He finds that he is actually safer with altitude, time and space to maneuver and correct for possible mistakes. He has been taught how and when to use an emergency parachute when mandatory in the country.</p> <p>Proper environment</p> <p>The take-off, landing area and flight path between them are easy and with good margins to any obstacle or other hazards. The take-off area shall be smooth and allowing for acceleration to flying speed before getting airborne (no cliff launch). The landing area shall be large and easy to reach by normal maneuvering with a good margin of height. If the landing cannot be seen from take-off, there shall be two instructors, one on take-off and one on landing with an established two-way communication between them.</p> <p>Planning is the key word.</p> <p>The student must now plan and prepare for each flight. He learns and practices the basic maneuvers, such as speed control, coordinated turns and combinations of them, using the brakes and/or weight shift, correction for wind drift and precision approaches and landings. The planning and decision-making (judgement) starts even before take-off and continues all the time. He must be ahead of the events, observe, evaluate, decide and act accordingly, like in all aviation.</p> <p>Drift and margins:</p> <p>All maneuvers shall be done close to the landing field and into the wind to avoid drifting out of reach of the landing area. Advanced maneuvers like 360° turns and slow flying shall be performed with extra caution and enough height and distance to the terrain to allow for corrections or recovery upon loss of control. Turns, downwind flying and slow speeds close to the ground</p>	<p>Өндөрт гулсах нислэг гэдэг нь харьцангуй чөлөөтэй манёвр хийх боломж бүхий хангалттай өндөрт, газрын гадаргуугаас хангалттай зайд нисэхийг хэлнэ.</p> <p>Сургалтын болон аюулгүй ажиллагааны зөвлөмжүүд</p> <p>Зорилго</p> <p>Энэ шатанд суралцагч хангалттай өндөрт, гэхдээ аюулгүй хязгаарын дотор гулсах нислэг үйлдэхэд суралцана. Бага багаар нислэгийн өндрийг ахиулснаар энэ шатанд суралцагч өндрийн айдсаа давж чаддаг болж эхэлнэ. Харин ч хангалттай өндөрт байх тусмаа илүү аюулгүй, ямар нэг алдаа гарлаа гэхэд засах, манёвр хийх цаг хугацаа, орон зай байна гэдгийг ойлгоно. Хэрэв тухайн улсад заавал шаарддаг бол, ослын буултын үед нөөц шүхэр хэрхэн ашиглахыг заалгасан байх ёстой.</p> <p>Тохиромжтой орчин</p> <p>Гарааны болон газардах талбай, нислэгийн зам харьцангуй хялбар, ямар нэгэн саад, эрсдэлтэй орчноос хангалттай хол байх ёстой. Гарааны талбайд элдэв саад бэрхшээлгүй, газраас тасрах хүртэл гүйх, хурд авах боломж бүхий байна (эгц хясаа байж болохгүй). Газардах талбай том, хангалттай өндөртэй үед энгийн манёвр хийж хялбар хүрч болохоор байна. Хэрэв газардах талбай гараанаас харагддаггүй бол дээр, доор хоёр сургагч багш байрлаж, станцаар зааварчилга өгнө.</p> <p>Төлөвлөлт хамгийн чухал.</p> <p>Энэ шатанд суралцагч нислэг бүрээ өөрөө төлөвлөж, бэлтгэл хийх ёстой. Хурдаа хянах, тоормос/жолоо болон биеийн шилжилтээ ашиглаж эргэлт хийх, салхинд чиглэлээсээ хазайх үед засах, газардах талбай руу суулт хийх, буух цэгээ нарийн тооцоолж сурах. Төлөвлөх, үнэлж цэгнэх, шийдвэр гаргах үйл явц нь гараа хийхээс ч өмнө эхэлж, нислэгийн турш үргэлжилнэ. Яг л онгоц жолоодохын адилаар үйл явдлыг урьдчилан харах, ажиглах, үнэлж дүгнэх, шийдвэр гаргах, нөхцөл байдалдаа тохирох үйлдэл хийх ёстой.</p> <p>Замаас хазайх ба хязгаарууд:</p> <p>Салхинд туугдан газардах бүсээс гарахаас сэргийлж бүх манёврууд газардах талбайд ойртсон үед, салхины эсрэг хийгдэнэ. Гэхдээ 360°-ын эргэлт болон удаашруулсан нислэг зэрэг ахисан шатны манёвруудыг маш болгоомжтой хийх, засах боломжтой өндөрт, хяналтыг алдсан тохиолдолд сэргэх боломжтой байхаар хийнэ. Газарт ойртсон үед эргэлт хийх, салхины уруу нисэх, хурд хасах зэргийг хатуу хориглоно.</p>

shall be strictly avoided. Approach shall be planned in good time and with a good height. The student shall also avoid flying alone.

Warning

It is warned against attempts to take off in cross, down, gusty or strong winds and to fly in unstable or turbulent conditions or in lift. Poor planning, preparation and take-off techniques may result in equipment failures or malfunctions, or failure to close leg loops, which may have the most serious consequences.

When all rating requirements have been met...

The student shall, when flying without the direct supervision of an instructor, only fly in beginner or intermediate environment with light to moderate smooth winds. Take-off shall only be done in approximately headwind. Lift or turbulence shall be avoided, or if not possible, flown straight through to calmer conditions in order to land in the ordinary landing area.

Before progressing to the next stage

It is of vital importance that the student knows the applicable theory, masters airspeed control in the lower speed range and is able to recognize and correct for stalls. He can identify his stress level and manage it.

SKILL REQUIREMENTS

- Planning: Insight, evaluations and decisions, flight plan, axes, drift, height, land marks
- Pre-flight check
- Mental state and stress level awareness, techniques to lower stress
- Take-off: Canopy raising and control, stop-line/decision, acceleration, liftoff, clearing terrain, transition to sitting position
- Shallow turns: Visual check, gentle to medium bank, drift correction
- Approach: Setting relative to terrain and wind, types of approach, hands up, straight final, overcoming gradient with speed
- Landing: Aiming towards a preset area, hands up and braking
- After landing: Checking traffic, leaving landing for next pilots
- Ground handling: Glider control while staying on the ground

KNOWLEDGE REQUIREMENTS

Pilot

- Physical factors: fitness and exhaustion, hydration, food, skin and eye protection, alcohol and drugs

Суултыг хангалттай өндөрт, хангалттай хугацаатай төлөвлөнө. Мөн энэ шатны суралцагч ганцаараа нисэж болохгүй.

Анхаарах зүйл

Хөндлөнгийн, арын, хүчтэй болон шилжлэг салхитай үед гараа хийхгүй байх, тогтворгүй, сэгсрэлттэй болон өргөлттэй агаарын үрсгал бүхий нөхцөлд нисэхгүй. Төлөвлөлт, бэлтгэл, гарааны техник муу байснаас далавч нурах, доголдох зэрэг ноцтой үр дагаварт хүргэх аюултай.

Бүх шаардлагыг хангасан тохиолдолд...

Сургагч багшийн шууд хяналтын доор нисэхгүй тохиолдолд суралцагч зөвхөн анхан болон дунд шатны нөхцөлд, багаас аядуу зөөлөн салхитай үед ниснэ. Гараа хийхдээ зөвхөн өөдөөс салхитай үед хийнэ. Өргөлт болон сэгсрэлттэй орчноос зайлсхийнэ. Боломжгүй бол нэвт гарч илүү тогтуун орчинд шилжсэний дараа ердийн газардах талбайд газардахыг эрмэлзэнэ.

Дараагийн шатанд дэвшихээс өмнө

Суралцагч хэрэглээний онолоо мэдэж, бага хурдтай үед агаар дахь хурдаа хянах аргыг бүрэн эзэмших, нуралтыг таних, засах чадварт суралцсан байх нь нэн чухал. Стрессийн түвшнээ тодорхойлж, түүнийг удирдах чадвартай болно.

ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ УР ЧАДВАР

- Төлөвлөлт: Өөрийн бодол, үнэлгээ ба шийдвэр, нислэгийн төлөвлөгөө, тэнхлэг, замаас хазайх, өндөр, газрын шинж байдал
- Нислэгийн өмнөх үзлэг
- Сэтгэл зүйн байдал болон стрессийн түвшингээ мэддэг байх, стресс бууруулах арга техникүүд
- Хөөрөх: Далавчаа босгох, хянах, гараа үйлдэхгүй зогсох шугам/ шийдвэр гаргах, хурд авах, тасрах, орчин тойронд саад байгаа эсэхийг шалгах, суудалдаа суух
- Гүехэн эргэлтүүд: эргэлтээ харж хянах, зөөлнөөс дунд зэрэг хүртэлх хазайлт, чиглэлээс хазайвал засах
- Суулт: газрын онцлог болон салхинаас хамаарч аль зүгээс суулт хийхээ тогтоох, суултын хэлбэрүүд, гар дээшээ, эцсийн байдлаар шулуун чиглэлтэй,
- Газардах: урьдчилан товлосон газар луугаа чиглэх, гар дээшээ, тоормос
- Газардсаны дараа: Бусад нислэгийг анзаарах, дараагийн нисгэгчид талбайг чөлөөлж өгөх
- Газрын бэлтгэл: Газар дээр далавчаа удирдах

ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ МЭДЛЭГ

Нисгэгч

- Бие бялдрын хүчин зүйлс: биеийн байдал, ядралт, шингэн нөхөх, хооллолт, арьс, нүдээ хамгаалах, согтууруулах ундаа, эм бэлдмэлийн хэрэглээ

- Psychological factors: Identify and lower stress, identify and express emotions
- Pilot in command: Responsibilities, abilities, necessity to complete any started flight

Aircraft

- Glider handling: Axes, speed control, slow flight
- Harness tuning: Fixing harness position and comfort
- Safety equipment: Emergency parachute, hook knife
- Equipment care

Aerodynamics

- Drift: Head or tail wind, crabbing, corrections in turns, penetration
- Stall: Description, in wind and lift gradients, dangers, recognition, avoidance and recovery
- Driving forces: On the ground: by running, in the air: weight (gravity)
- Lift: Axes, difference in pressure from aerofoil, airspeed, angle of attack
- Drag: Increasing with airspeed and angle of attack

Meteorology

- Wind: Meteorological wind, at take-off, in landing and along the flight path, indicators, gradient
- Local conditions: Terrain effects, valley, Venturi effect, obstructions, corners, rotors
- Turbulence, gusts
- Mechanical: Wind speed gradient, wake of glider or obstacle, lee, rotor
- Shear: Mountain shape, gradient, inversion layer, catabatic flow
- Thermal: Mixing of air zones, gradient, combination with wind

Rules

- Local and site(s)
- Right of way rules: Crossing, slope, thermals, aircraft categories priorities
- National Hang Gliding and Paragliding Association Safety
- Flight planning: Process, information, observation, evaluation, decision, execution
- Flying exercises: Description, aim, procedures, execution, errors and dangers

EXPERIENCE REQUIREMENTS

- At least 4 practice days
- At least 10 flights

ATTITUDE REQUIREMENTS

- The instructor shall be convinced that the student is able to take care of his own and others' safety, while altitude gliding within the recommendations given.

- Сэтгэл зүйн хүчин зүйлс: стрессээ таних, бууруулах, сэтгэл хөдлөлөө таних, илэрхийлэх
- Нислэг үйлдэж буй нисгэгч: хариуцлага, чадварууд, эхэлсэн нислэгээ зайлшгүй дуусгах шаардлага

Нисэх төхөөрөмж

- Далавчаа удирдах: тэнхлэгүүд, хурдаа хянах, удааширсан нислэг
- Суудлаа тохируулах: суудлын байрлалыг тохируулах, тав тухтай байдал
- Аюулгүй ажиллагааны хэрэгсэл: аврах шүхэр, махир хутга
- Далавч хэрэгслээ арчлах

Аэродинамик

- Замаас хазайх: өөдөөс болон хойноос чигтэй салхи, замаас гарах, эргэлтээ засах, нэвтрэх
- Далавч унтрах: тодорхойлолт, салхины болон өргөлтийн шатлал, аюул, унтралтыг таних, зайлсхийх, сэргээх
- Хөтлөх хүч: газар дээр: гүйлт, агаарт: жин (татах хүч)
- Өргөлт: тэнхлэгүүд, далавчны их биеээс ирэх даралтны ялгаа, агаар дахь хурд, давшилтын өнцөг
- Хойш чангаах хүч: Агаар дахь хурд болон давшилтын өнцгөөс хамаарч нэмэгдэх

Цаг уур

- Салхи: агаар мандлын салхи, гараа болон газардах талбай дээрх салхи, нислэгийн зам дагуух салхи, үзүүлэлтүүд, шатлал
- Орон нутгийн нөхцөл: газар орны нөлөө, хөндий, Venturi нөлөө, саад, өнцөг, эргүүлэг
- Сэгсрэлт, шилжлэг салхи
- Механик: салхины хурдны шатлал, өөр далавч болон саадаас үүсэх хуйлралт, нөөлөг, эргүүлэг
- Агаарын массуудын тулгарал: уулын хэлбэр, шатлал, инверсийн давхарга, катабатик урсгал
- Термал: агаарын бүсүүдийн хоршил, шатлал, салхитай хослох

Дүрэм журам

- Орон нутгийн болон тухайн нислэгийн талбайн журам
- Баруун гарын дүрэм: зөрөх, хяр дээр, термалд, агаарын хөлгийн ангиллаар
- Тухайн улсын ханглайдинг, параглайдингийн холбооны аюулгүй ажиллагааны дүрэм журам
- Нислэг төлөвлөх: үйл явц, мэдээлэл, ажиглалт, үнэлгээ, шийдвэр, гүйцэтгэл
- Нислэгийн дадлага: тайлбар, зорилго, журам, гүйцэтгэл, алдаа ба аюул осол

ДАДЛАГА

- Дор хаяж 4 бүтэн өдөр дадлага хийх
- Дор хаяж 10 нислэг үйлдэх

ХАНДЛАГА

- Өндөрт гулсах нислэг хийхдээ суралцагч өгөгдсөн зааварчилга, аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хүрээнд өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж чадна гэсэн итгэл үнэмшил сургагч багшид төрсөн байх ёстой.

Stage 3 – Active flying (green)

Active flying is maintaining the normal flying mode in turbulent air. It includes keeping the angle of attack within the limits, managing pitch and roll movements, preventing and recovering from collapses, tucks and stalls, and quick descent techniques.

Instructional and safety recommendations

Objective

This stage introduces the student to the effects of turbulence on glider behavior and to the appropriate recovery techniques. Dealing with turbulence precedes the next stages because lifting air is often accompanied by turbulence nearby. Ground handling introduced in the previous stage needs endless training at this stage and in all the next ones. Turbulence causes shifts along and rotations around the three axes of the glider. The student must know and distinguish glider pitch, roll and yaw movements due to turbulence, glider self-recovery and control inputs. He learns the active and passive ways to prevent collapses, the recovering techniques and is informed about the glider certification tests. At this stage, the student simulates pitch and roll movements, gets used to them and learns to dampen them efficiently. He learns to collapse the wing tips, perform big ears, use the speed system and control the glider by weight shift. If there is enough height, mild asymmetric collapses can be performed (slightly bigger than big ears folding), followed by different recovery techniques. A thorough knowledge of emergency procedures is gained. He becomes then able to recognize turbulence induced collapses or dives, to execute prompt and correct recovery, and to use an emergency parachute.

Proper environment

As calm conditions as possible, good spacing from other traffic, maximum height over the terrain and close enough to the landing place. If available, the exercises should be performed over water with beginners' gliders. The exercises can also be made with an instructor under a tandem wing.

Warning

It is warned against too fast progression, overconfidence, inattention, ignorance, risk taking, misjudgments and lack of skills. Poor technique or distractions leading to the loss of sail control when launching can result in the sail overshooting and collapsing. Real life effects of turbulence on gliders are much stronger than simulated in calm conditions, but the recovery principles are the same. From now on, the student may fly on his own, but under supervision of an instructor. He may experience the 'intermediate' or 'Icarus syndrome', which means believing he now knows and masters everything, and that neither he nor the equipment have limitations...

3-р шат – Идэвхтэй нислэг (ногоон)

Идэвхтэй нислэг гэдэг нь сэгсрэлттэй агаарын орчинд нислэгээ хэвийн горимоор үргэлжлүүлэхийг хэлнэ. Давшилтын өнцгөө хязгаарлалтын хүрээнд барих, өлийх/тонгойх болон хазайх хөдөлгөөнийг удирдах, далавчны нуралт, хумилт, унтралтаас сэргийлэх, сэргээх, түргэн доошлох техникүүд зэргийг багтаана.

Сургалтын болон аюулгүй ажиллагааны зөвлөмжүүд

Зорилго

Энэ шатанд суралцагч сэгсрэлттэй агаар далавчинд ямар нөлөө үзүүлэхийг мэдэж авч, мөн далавч нурах тохиолдолд сэргээх техникт суралцана. Сэгсрэлттэй агаарын учрыг олох нь дараагийн шатанд шилжихээс өмнө заавал хийгдэх ёстой зүйл. Учир нь өргөлттэй агаарын ойролцоо заавал сэгсрэлттэй орчин байдаг. Өмнөх шатанд эхэлсэн газрын бэлтгэлийг энэ болон дараагийн шатуудад ч дахин давтан хийх ёстой. Сэгсрэлттэй агаар нь далавчны 3 тэнхлэгийн дагуу шилжилтүүд болон эргэлтүүд үүсгэдэг. Сэгсрэлттэй орчинд далавчны өлийх/тонгойх, хазайх, мушгирах хөдөлгөөнүүдийг таних, ялгах, далавч өөрөө сэргэх, эсвэл удирдлага хийж сэргээх тухай суралцагч мэдэж авна. Нуралтаас сэргийлэх идэвхтэй ба идэвхгүй аргууд, сэргээх техникүүдийг сурч, далавчны тест нислэг хэрхэн хийгддэг тухай ойлголт авна. Мөн далавчны өлийх/тонгойх, хазайх хөдөлгөөнийг өдөөж, түүнд өөрийгөө дасгах, буцаагаад хурдан засахад суралцана. Чих тавих, хурдны системийг ашиглах, биеийн жинг шилжүүлэх замаар далавчаа удирдах зэргийг сурна. Хангалттай өндөрт, чих тавихаас арай илүү хэмжээнд, гэхдээ маш зөөлөн тэгш хэмт бус нуралт үүсгэн, түүнийг янз бүрийн аргаар сэргээх техникт суралцана. Ослын үеийн дүрэм журмын талаар гүн мэдлэг авна. Сэгсрэлттэй агаарын урсгалаар үүсгэгдсэн нуралт, шумбалтыг таних, хурдан шаламгай бөгөөд зөв сэргээлт хийх, ослын шүхэр хэрэглэх чадвартай болно.

Тохиромжтой орчин

Аль болох тайван орчин нөхцөлд, бусад нисгэгчдээс хангалттай зайнд, газрын гадаргуугаас максимум өндөрт, газардах талбай боломжийн ойрхон зайд байхаар байна. Хэрэв боломжтой бол, дээрх дасгалуудыг усан дээр, анхан шатны далавчаар хийх хэрэгтэй. Эсвэл сургагч багшийн хамт тандем далавчаар хийж болно.

Анхаарах зүйл

Хэтэрхий хурдан ахих, өөртөө хэт итгэлтэй, анхаарал тоомжиргүй хандах, эрсдэлтэй зүйл турших, буруу дүгнэх, үр чадвар дутуу байх нь осолтойг үргэлж сана. Гараа хийх үед техник муу, анхаарал сарнисан зэргээс далавчаа хянаж чадахгүй бол далавч давж унах, нурах үр дагаварт хүрнэ. Бодит байдал дээр сэгсрэлттэй агаарын далавчинд үзүүлэх нөлөө нь тогтуун нөхцөлд зориуд хийсэн үйлдлээс хамаагүй илүү хүчтэй байх ч сэргээх зарчим нь адилхан. Одооноос эхлээд суралцагч бие даан нисэж болох боловч сургагч багшийн шууд бус удирдлаган доор ниснэ. Энэ үед суралцагч “дунд шатны” буюу “Икарус” синдромд өртөж болзошгүй үе. Одоо бүгдийг мэддэг, чаддаг болсон, өөрөө ч, далавч нь ч ямар нэгэн хязгаарлалтгүй г.м.

Accidents can happen already in ground handling, and there is no such thing as a complete pilot as even experienced pilots keep learning during their whole career.

When all rating requirements have been met...

The student can fly freely within safe limitations, and as long as a higher stage is not required by regulation. He has the responsibility to seek further instruction when necessary. It is recommended in the beginning to use the rules above as guidance for safe flying.

Before progressing to the next stage

The student shall have a variety of experiences from different sites and conditions. The flying process shall be automated, so that reactions are fast and correct in the different situations/exercises he has to master. He is aware of his physical and emotional state and takes it in consideration when deciding to fly or not.

SKILL REQUIREMENTS

- Take-off: Stop-line awareness and decision before accelerating for take-off
- Speed control: Minimum sink speed, best glide angle including with lift/sink or wind
- Turns: Ordinary speed and at minimum sink, coordinated, no sign of stall
- Pitch and roll control: Simulation and dampening swings (stabilizing the glider), speed bar
- Big ears: Collapsing wingtips, holding them, recovering them; big ears and weight shift turns; big ears plus speed system; other descending techniques
- Asymmetric collapse: Like a one side big ear or slightly bigger if possible – inducing, holding, recovery
- Precision approach and landing: Safe and inside an area decided by the instructor, figure 8 and standard aircraft patterns
- Tandem with instructor (gentle maneuvers not needing a lake): Asymmetric collapse, spiral dive (optional)
- Emergency parachute deployment: Simulation (optional)

KNOWLEDGE REQUIREMENTS

Pilot

- Psychological factors: Mental strength factors, factors interacting with stress (motivation, emotions, concentration, personality), actions to lower stress, stress and self-confidence measurement
- Learning process: Description, objectives, individual progress, safety
- Judgement: Insight, evaluations, decisions, actions, being ahead of the game, awareness and tracking of other gliders

Гэтэл газрын бэлтгэл хийх үед ч осол гарах боломжтой. Бүрэн боловсорсон нисгэгч гэх ойлголт бараг байхгүй. Туршлагатай нисгэгч нар ч амьдралынхаа туршид суралцсаар байдаг.

Бүх шаардлагыг хангасан тохиолдолд...

Хэрэв тухайн улсын дүрэм журмаар тусгайлан заагаагүй бол энэ шатны суралцагч аюулгүй хязгаарын хүрээнд чөлөөтэй нисэж болно. Цаашид суралцах шаардлагатай гэж үзвэл ахисан шатны сургалт авах нь тухайн хүний мэдэх хэрэг. Аюулгүй нисэхийн тулд дээр дурьдсан дүрмүүдийг мөрдлөг болгохыг зөвлөж байна.

Дараагийн шатанд дэвшихээс өмнө

Суралцагч янз бүрийн байршил, нөхцөлд нисэж туршлага хуримтлуулна. Нислэгийн үед хийх үйлдлүүдийг гартаа оруулснаар янз бүрийн нөхцөлд, дасгалууд гүйцэтгэх үед хариу үйлдэл хурдан бөгөөд зөв болно. Бие бялдрын болоод сэтгэл хөдлөлийн байдлаа мэддэг, нисэх эсэх шийдвэр гаргахдаа түүнийгээ харгалзаж үздэг болно.

ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ УР ЧАДВАР

- Гараа: Гараа үйлдэхгүй зогсох шугамыг мэдэх, хурд авахаас өмнө шийдвэр гаргах
- Хурдаа хянах: живэлтийн минимум хурд, өргөлт/живэлт, эсвэл салхинд гулсалтын хамгийн сайн өнцөг
- Эргэлт: ердийн хурд ба минимум живэлт, өндөр авахгүй/алдахгүй эргэлт, унтралтын шинж тэмдэггүй
- Өлийх/тонгойх болон хазайхыг хянах: Симуляци ба савлалтыг багасгах (далавчаа тогтворжуулах), speed bar
- Чих тавих: далавчны үзүүрийг нураах, барих, сэргээх; чих тавих болон биеийн жинг шилжүүлэн эргэлт үйлдэх; чих тавих ба хурдны систем; доошлох бусад техникүүд
- Тэгш хэмт бус нуралт: нэг талд чих тавих, эсвэл нэг талд нь арай том чих тавих – чих үүсгэх, барих, сэргээх
- Нарийвчлалтай сууж, газардах: аюулгүй бөгөөд сургагч багшийн заасан талбайн дотор газардах, Наймын тоо болон агаарын хөлгийн стандарт үйлдлүүд
- Сургагч багштай тандем нислэг хийх (зөөлөн маневрууд, заавал нууран дээр биш): Тэгш хэмт бус нуралт, спираль шумбалт (нэмэлтээр)
- Аврах шүхэр татах: Симуляци (нэмэлтээр)

ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ МЭДЛЭГ

Нисгэгч

- Сэтгэл зүйн хүчин зүйлс: Сэтгэлийн тэнхээ, стресстэй харилцан үйлчлэх хүчин зүйлс (сэдэл, сэтгэл хөдлөл, төвлөрөх чадвар, зан чанар), стресс бууруулах үйлдлүүд, стресс болон өөртөө итгэлтэй байдлыг хэмжихүй
- Сурах үйл явц: тодорхойлолт, зорилтууд, хувь хүний ахиц дэвшил, аюулгүй ажиллагаа
- Тунгаах чадвар: өөрийн бодол, үнэлгээ, шийдвэр, үйлдэл, урьдчилан тооцоолох чадвар, бусад нисгэгчдийн байрлал, замыг мэдэж байх

Aircraft

- Removing debris from inside canopy
- Awareness of trim checking
- Cleaning canopy and harness

Aerodynamics

Pitch and roll movements: Creation by outside influence (glider reaction), glider stability, control inputs

- Big ears: Way to descend and increase glider stability by increased wing loading and decreased aspect ratio, dangers
- Collapse: Creation by outside influence (glider reaction), glider stability, control inputs
- Spin: At take-off, turning, spin recovery, wind gradient, in landing

- Spiral, skid and slip
- Stall: In turbulence, unexpected lift, turns, gradient, downwind, dangers

• Load: Weight, G-force, in turns, pull-outs, wind and lift gradients, gusts and turbulence

- Emergency parachute: Aerodynamic brake, pulling in glider canopy

Meteorology

- Turbulence, gusts
- Mechanical: Behind or lee of obstructions, trees, buildings, hills, wind gradient
- Wind shifts and shears: Description, dangers
- Thermal: Tends to build as the day progresses until late afternoon
- Deteriorating weather as a source of turbulence: Fronts, cumulonimbus, high winds, gusts, strong lift
- Breeze: Difference from wind, creation, sea, mountain, valley, strength, effects

Rules

- Third part liability insurance, when available
- School and training
- Airspace: Local airspace limitations

Critical situations

- Preparation: Causes, recognition, avoidance, corrections, training (simulation)
- Poor take-off: Sight downward, poor wing control, overly aggressive or weak acceleration, wing shooting forward, turn back into hill, getting into harness too soon
- Knowing how to take and release wraps (shortening brake lines) when needed
- Stall: In turbulence, unexpected lift, turns, gradient, downwind, dangers
- Unusual attitudes: Turbulence, pitch ups and downs, collapse recovery

Нисэх төхөөрөмж

- Далавчны их бие дотор орсон хог шороо, гадны биетийг зайлуулах
- Ирмэг шалгах тухай мэдлэг
- Далавч, суудлаа цэвэрлэх

Аэродинамик

Өлийх/тонгойх болон хазайх хөдөлгөөн: Гадны нөлөөгөөр үүсэх (далавчны хариу үйлдэл), далавчны тогтвортой байдал, хянах аргууд

- Чих тавих: доошлох арга зам, далавчийг илүү ачаалж, далавчны урт, өргөний харьцааг багасгаснаар далавчны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, байж болох аюул
- Нуралт: гадны нөлөөгөөр үүсэх (далавчны хариу үйлдэл), далавчны тогтвортой байдал, хянах аргууд
- Эргэлдэх хөдөлгөөн: гараан дээр, эргэлт үйлдэх үед, сэргээх арга, салхины шатлал, газардах үед
- Спираль, хазайлттай эргэлтийн үед шарвалт, гулсалт үүсэх
- Stall: Сэгсрэлт, гэнэтийн өргөлт, эргэлт, салхины шатлал, доош чиглэлтэй салхи, аюул
- Ачаалалт: жин, төвөөс зугатаах хүч, эргэлтэнд, pull-outs, салхины ба өргөлтийн шатлалууд, шилжлэг салхи ба сэгсрэлт
- Аврах шүхэр: аэродинамик тоормос, далавчаа хумьж авах

Цаг уур

- Сэгсрэлт, шилжлэг салхи
- Механик: Аливаа саад, мод, барилга, уул толгойн ард үүсэх нөөлөг, салхины шатлал
- Салхины өөрчлөлт ба агаарын массудын тулгарал: Тодорхойлолт, аюул
- Термал: Өдөр эхлээд үд нилээд хэвийтэл үүсэх хандлагатай байна.
- Цаг агаар мүүдах нь сэгсрэлт үүсэх шалтгаан: хүйтэн үрсгалын фронт, борооны бөөн үүл хуралдах, өндрийн салхи, шилжлэг салхи, хүчтэй өргөлт
- Сэвшээ салхи: салхинаас ялгаатай чанар, үүсэх, далай, уул, хөндий, хүч, нөлөө

Дүрэм журам

- Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал (боломжтой бол)
- Сургууль ба сургалттай холбоотой
- Агаарын орон зай: тухайн орон нутгийн агаарын орон зайн хязгаарлалтууд

Эрсдэлтэй нөхцөл байдал

- Бэлтгэл: шалтгаан, таньж мэдэх, зайлсхийх, залруулах, сургалт (симуляцийн орчинд)
- Муу гараа: харц доош чиглэсэн, далавчаа хянах чадвар муу, хэт огцом, эсвэл сүл хурд авах, далавч урдуур давах, уул рүү буцаж эргэх, хэтэрхий эрт суудалдаа суух
- Хэрэгтэй үед гараа ороох/буцаах замаар жолоо/тоормосоо яаж богиносгох, уртасгахаа мэддэг байх
- Унтралт: Сэгсрэлт, гэнэтийн өргөлт, эргэлт, салхи уруудах үед, аюул
- Хэвийн бүс төлөв: Сэгсрэлт, далавч өлийх/тонгойх, нуралтыг сэргээх

- Poor approach and landing: Unstructured, no clear plan, over landing field, low turns, slow flight close to terrain

First aid

- In accordance with appropriate authority’s recommendations

EXPERIENCE REQUIREMENTS

- Basic elements of SIV course suggested
- Emergency parachute opening clinic recommended
- At least 3 successful flights with the above-mentioned exercises: pitch and roll control, big ears, asymmetric collapse

ATTITUDE REQUIREMENTS

- The instructor shall be convinced that the student is able to take care of his own and others’ safety within applicable rules and regulations, recommendations and code of good practice, while operating alone.

- Алдаатай суулт, газардалт: тодорхой бус, төлөвлөгөөгүй, талбайгаас хэтэрч газардах, нам өндөрт орсон үед эргэлт үйлдэх, газарт ойр удааширсан нислэг хийх

Анхны тусламж

- Зохих байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу анхны тусламж үзүүлэх

ДАДЛАГА

- SIV сургалтын үндсэн элементүүдийг мэдэх
- Аврах шүхэр задлах танхимын сургалт авсан байхыг зөвлөнө.
- Дээр дурдсан далавч өлийх/тонгойх ба хазайхыг хянах, чих тавих, тэгш хэмт бус нуралтыг засах зэрэг дасгалуудыг багтаасан нислэгийг дор хаяж 3 удаа амжилттай үйлдсэн байх.

ХАНДЛАГА

- Бие даан нислэг үйлдэхдээ суралцагч батлагдсан дүрэм журам, зөвлөмж, үйл ажиллагааны жишиг стандартын хүрээнд өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж чадна гэсэн итгэл үнэмшил сургагч багшид төрсөн байх ёстой.

Stage 4 – Soaring (blue)

Soaring is using updraughts to extend the flight duration, be it flying on a ridge facing wind or in thermals, or even in wave.

Instructional and safety recommendations

Objective

This stage is to make sure the pilot can safely fly any type of soaring within safe limitations, also under pressure as in traffic, demonstrations and local/friendly competitions. Soaring has several levels, from easy ridge or thermal conditions and mild maneuvers with large margins, to demanding conditions with smaller margins. It requires fast and accurate evaluations of conditions and situation, combined with fast and precise maneuvering. A pilot plans carefully and is always well ahead of the situation, so that in critical cases he performs the right reaction without delay. At this stage, the student gets more airtime and the flying can become self-controlled, but there is less room for mistakes and errors. His experience is still low, any setback needs to be avoided. A thoroughly planned progression is therefore important. Exercises shall be simple in the beginning, with large safety margins. The launch and lower speed range control must be mastered, like coordinated turns with a minimum height loss, while calculating drift, keeping an eye on traffic and respecting traffic rules. The student knows the performance curves, flying speeds (speed polar), design limitations and load factors of his glider. Later on, when there is enough height, he can study pitch and roll limits.

4-р шат – Халин нисэх (хөх)

Халин нисэх гэдэг нь нислэг үргэлжлэх хугацааг сунгахын тулд ямар нэгэн өргөлт ашиглан нисэхийг хэлнэ. Энэ нь хярын салхи, термал, бүр агаарын үелзэл ч байж болно.

Сургалтын болон аюулгүй ажиллагааны зөвлөмжүүд

Зорилго

